

ТАГНАХ АЖИЛЛАГААНЫ БА ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙ, СУДАЛГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Ч.НЭРГҮЙ

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага,
стратеги профессорийн багийн дэд профессор,
докторант, хурандаа

Монгол Улсын тагнах ажиллагааны ба гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалт гадаадын судлаачдын анхаарлыг ч татаж тэд манай хуулийг судалж байна. Оросын Холбооны Улсын судлаач С.Н.Якушевын “Оросын Холбооны Улс ба Монгол Улсын гүйцэтгэх ажлын эрх зүйн харьцуулсан тодорхойлолт ба гүйцэтгэх ажлын үр дүнг эрүүгийн шүүн таслах ажиллагаанд ашиглах нь”¹ өгүүлэл, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын доктор, профессор Бернд Шюнеманны “2002 онд батлагдан гарсан “Монгол улсын Эрүүгийн байцаан Шийтгэх Хуульд шинжлэх ухааны тайлбар” гэсэн өгүүлэлд хийсэн “гүйцэтгэх ажил явуулж олсон нотлох баримтын тухай” дүгнэлт² үүнийг нотолж байна. 2007 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Стратегийн судалгааны хүрээлэн, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих асуудал судлах Женевийн төвөөс хамтран зохион байгуулсан “Аюулгүй байдлын салбарын шинэчлэлийг төгөлдөршүүлэх болон хүний аюулгүй байдлыг хангах асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал тагнуулын албад, түүний ажиллагааг хуулиар зохицуулах, хяналт тавих асуудлыг хөндсөн байна.³ 1910 оны Зургаадугаар сарын сүүлчээр АНУ-ын Монтерейгийн Тэнгисийн цэргийн сургуулийн төгсөлтийн дараахь шатны сургалтын цэрэг, иргэний харилцааны төвийн Латин Америкийн бүс нутаг хариуцсан захирал, профессор, доктор Томас Брунэ Монголд ирж Үндэсний тагнуулын

¹ Федеральный журнал “Уголовное судопроизводство” 2006 г. ¹⁴ Якушев С.Д. “Сравнительная характеристика правовых аспектов оперативной деятельности и использование ее результатов в уголовном судопроизводстве России и Монголии” стр 34-40.

²ХБНГУ-ын доктор, проф Бернд Шюнеманн “Монгол улсын ЭБШХ-д шинжлэх ухааны тайлбар” илтгэл өгүүлэл. 2003. Эмхтгэлийн 44-47-р тал.

³Ханс Борн, Иан Лей. Подотчётность спецслужб: правовые нормы, опыт и рекомендации, 2005.

академийн эрдэмтэн, багш нарт “Ардчилсан нийгэм дэх тагнуулын байгууллагын шинэчлэл” гэсэн лекц уншсаны дараа судлаачид, багш нартай санал солилцохдоо “Монголын тагнуулын байгууллагын шинэчлэл, түүний эрх зүйн зохицуулалтын талаар хамтарсан бүтээл туурвих санал тавьж байсан.

“Аюулгүй байдлыг хангах тухай” хууль, “Гүйцэтгэх ажлын тухай” хууль, “Тагнуулын байгууллагын тухай” хууль батлагдсанаас хойш тагнах үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар асуудал дэвшүүлсэн онол практикийн болон эрдэм шинжилгээний хурал хэд хэдэн удаа зохион байгуулагджээ. Тухайлбал Үндэсний тагнуулын академиас “Гүйцэтгэх ажлын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох нь”⁴ гэсэн сэдвээр 2003 онд зохион байгуулсан онол практикийн хуралд тагнах үйл ажиллагаа ба гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын судлаачид “Эрүүгийн хэргийн нотлох баримтын талаар Эрүүгийн байцаан шийтгэх хууль, гүйцэтгэх ажлын тухай хуулийн зарим заалтыг боловсронгуй болгох тухай асуудал”⁵, “Гүйцэтгэх ажлын тухай хуулийн хэрэгжилтийн байдал, шийдвэрлэх асуудал, арга зам”⁶, “Гүйцэтгэх ажил ба захиргааны эрх зүйн уялдаа холбоо”⁷, “Гүйцэтгэх ажилтны ёс зүй”⁸, “Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжид хүний эрхийг хамгаалах талаар тусгасан нь”⁹, “Гүйцэтгэх ажлын эрх зүйг боловсронгуй болгох зарим асуудал”¹⁰, “Гүйцэтгэх ажлын байгууллагуудын ажлын уялдаа холбоог хуулиар зохицуулах ажлыг боловсронгуй болгох нь”¹¹, “Гүйцэтгэх

⁴ “Гүйцэтгэх ажлын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох нь” онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2003. Эмхтгэсэн Д.Тунгалаг, Л.Батдолгор.

⁵ С.Бямбадорж, А.Бат-Эрдэнэ. “Эрүүгийн хэргийн нотлох баримтын талаар Эрүүгийн байцаан шийтгэх хууль, гүйцэтгэх ажлын тухай хуулийн зарим заалтыг боловсронгуй болгох тухай асуудал” онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд УБ. 2003.4-7-р тал.

⁶ Ш.Ганболд. “Гүйцэтгэх ажлын тухай хуулийн хэрэгжилтийн байдал, шийдвэрлэх асуудал, арга зам” онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2003. 8-16-р тал.

⁷ Г.Цэрэнпунцаг. “Гүйцэтгэх ажлын болон захиргааны эрх зүйн уялдаа холбоо” онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2003. 17-28-р тал.

⁸ Д.Баатар. “Гүйцэтгэх ажилтны ёс зүй” онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2003. хуудас 29-54.

⁹ Х.Батгүн. “Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжид хүний эрхийг хамгаалах талаар тусгасан нь” онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2003. 55-61-р тал.

¹⁰ Ш.Мягмарцэрэн. “Гүйцэтгэх ажлын эрх зүйг боловсронгуй болгох зарим асуудал” онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2003. 62-71-р тал.

¹¹ П.Хосбаяр. “Гүйцэтгэх ажлын байгууллагуудын ажлын уялдаа холбоог хуулиар зохицуулах ажлыг боловсронгуй болгох” онол практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ. 2003. 68-72-р тал.

ажилд тавих прокурорын хяналт”¹², “Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний халдашгүй эрхийг хязгаарлах асуудлыг гадаад орнуудын болон Монгол Улсын хуулиар зохицуулсан нь”¹³ гэсэн сэдвүүдийг судалж илтгэл тавьсан нь тагнах үйл ажиллагаа ба түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход бас нэг алхам болсон гэж үзэж байна.

Мөн 2004 онд Цагдаагийн ерөнхий газар ба Эрүүгийн цагдаагийн газраас “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд гүйцэтгэх ажилтай холбоотой заалтуудыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх нь”¹⁴ сэдвээр зохион байгуулсан онол практикийн хуралд “Гүйцэтгэх ажлын үр дүнг ашиглах нь”¹⁵, “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгагдсан гүйцэтгэх ажил явуулахтай холбоотой заалтуудын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн онолын үндэс”¹⁶, “Гүйцэтгэх ажлын нэр томъёог нэг мөр ойлгох нь”¹⁷, “Гүйцэтгэх ажлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд шүүхийн байгууллагаас оролцох хэм хэмжээг хуулиар зохицуулах шаардлага”¹⁸, “Гүйцэтгэх ажилд прокурорын байгууллагын хяналтын хэрэгцээ, шаардлага, ач холбогдол”¹⁹, “Гэмт хэрэг илрүүлэхэд гүйцэтгэх ажлыг мөрдөн байцаалтад ашиглах арга зам”²⁰ гэсэн сэдвээр судалгаа хийж, илтгэл тавьж тагнах үйл ажиллагааны ба гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтын асуудлын талаар хөндсөн байна.

2010 онд ТЕГ-ын Үндэсний тагнуулын Академиас зохион байгуулсан “Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалт” сэдэвт онол-практикийн хуралд

¹² Б.Жаргалсайхан. Гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналт”, онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2003. 73-88-р тал.

¹³ Л.Батдолгор. “Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний халдашгүй эрхийг хязгаарлах асуудлыг гадаад орнуудын болон Монгол Улсын хуулиар зохицуулсан нь” онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2003. 89-95-р тал.

¹⁴ Эрүүгийн цагдаагийн газар. онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2004.

¹⁵ В.Чулуунбат. “Гүйцэтгэх ажлын үр дүнг ашиглах нь “онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2004. 5-21-р тал.

¹⁶ С.Жанцан. “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгагдсан гүйцэтгэх ажил явуулахтай холбоотой заалтуудын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн онолын үндэс” “онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2004. 22-32-р тал.

¹⁷ Б.Наранбаатар. “Гүйцэтгэх ажлын нэр томъёог нэг мөр ойлгох нь” “онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2004. 33-39-р тал.

¹⁸ Н.Төрбат. “Гүйцэтгэх ажлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд шүүхийн байгууллагаас оролцох хэм хэмжээг хуулиар зохицуулах шаардлага” “онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2004. 40-44-р тал.

¹⁹ Б.Цэрэнбалтав. “Гүйцэтгэх ажилд прокурорын байгууллагын хяналтын хэрэгцээ, шаардлага, ач холбогдол” “онол практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2004. 45-61-р тал.

²⁰ В.Отгонбаяр. “Гэмт хэрэг илрүүлэхэд гүйцэтгэх ажлыг мөрдөн байцаалтанд ашиглах арга зам” “онол практикийн хурлын илтгэлийн эмхтгэлд. УБ. 2004. 62-66-р тал.

“Тагнах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онол, практикийн асуудал”²¹, “Гүйцэтгэх ажлын тухай хуулийг боловсронгуй болгох нь”²², “Цэргийн тагнуулын байгууллагаас гүйцэтгэх ажил явуулах үндэслэл, түүний эрх зүйн зохицуулалт”²³, “Мөрдөн байцаалтын шатанд явуулах гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтын асуудал”²⁴, “Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтын асуудлаар тагнуулын ажилтнуудын дунд явуулсан санал асуулгын дүнгийн тухай”²⁵, “Хуульчлагдсан гүйцэтгэх ажлын зарчмууд, тэдгээрийн хэрэгжилтийн талаар”²⁶, “Гүйцэтгэх ажлын эрх зүйн орчны зарим асуудал”²⁷, “Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хууль, тогтоомжийг боловсронгуй болгох зарим асуудал”²⁸, “Мөрдөн шалгах ажиллагаанд гүйцэтгэх ажлын үүрэг, чиг хандлага”²⁹, “Тагнуулын байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулах зарим асуудал”³⁰, “Хилийн тагнуулын газраас гүйцэтгэх ажил явуулахад

²¹ Л.Батдолгор” Тагнах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онол, практикийн асуудал” “Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалт” сэдэвт онол-практикийн хурлын эмхтгэлд. УБ.2010. 4-24-р тал.

²² Ш.Ганболд. “Гүйцэтгэх ажлын тухай хуулийг боловсронгуй болгох нь” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ. 2010. 25-32-р тал.

²³ П.Батжаргал. “Цэргийн тагнуулын байгууллагаас гүйцэтгэх ажил явуулах үндэслэл, түүний эрх зүйн зохицуулалт” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ.2010. 33-39-р тал.

²⁴ Ц.Батцэнгэл. “Мөрдөн байцаалтын шатанд явуулах гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтын асуудал” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд УБ.2010. 41-46-р тал.

²⁵ Д.Зоригт. Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтын асуудлаар тагнуулын ажилтнуудын дунд явуулсан санал асуулгын дүнгийн тухай. Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ. 2010. 47-53-р тал.

²⁶ С.Жаргалсайхан. “Хуульчлагдсан гүйцэтгэх ажлын зарчмууд, тэдгээрийн хэрэгжилтийн талаар” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ. 2010.54-60-р тал.

²⁷ С.Гомбо. “Гүйцэтгэх ажлын эрх зүйн орчны зарим асуудал” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ.2010.61-67-р тал.

²⁸ Б.Мөнхбаяр, С.Тулга. “Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хууль, тогтоомжийг боловсронгуй болгох зарим асуудал” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ.2010.68-77-р тал.

²⁹ Р.Чингис. “Мөрдөн шалгах ажиллагаанд гүйцэтгэх ажлын үүрэг, чиг хандлага” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ.2010.78-85-р тал.

³⁰ Д.Өлзийбат. “Тагнуулын байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулах зарим

тулгамдаж буй эрх зүйн зарим асуудал”³¹, “Гүйцэтгэх ажлын тухай хуулийг боловсронгуй болгох зарим асуудлууд”³², “Гүйцэтгэх ажлын зарчимд анхаарах асуудал, тэдгээрийг боловсронгуй болгох нь”³³, “Төр нийгмийн зүтгэлтний амь биед халдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох гүйцэтгэх ажлын эрх зүйн зарим асуудал”³⁴ судалгааны өгүүллүүдэд тагнах үйл ажиллагаа ба гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох талаар ихээхэн ахиц гаргасан гэж дүгнэж болно.

Тагнах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийг төгөлдөршүүлэхтэй холбоотой тухайлбал, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай байлгах, тагнуулын арга, хүч, хэрэгслийг Монгол улсын Эрүүгийн хуульд заасан ТЕГ-ын харъяаллын хүнд, онц хүнд хэрэг, гэмт этгээдүүдтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ашиглах асуудлыг боловсронгуй болгох, тагнах үйл ажиллагаанд хамтран оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхой болгох, гүйцэтгэх ажлын арга, хүч, хэрэгслээр олсон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх нотолгоо болох үр дүн, мэдээ, баримтыг ашиглах эрх зүйн хэм хэмжээг төгөлдөршүүлэх, тагнах үйл ажиллагаанд тавих олон чиглэлийн хяналтыг олон улсын тагнах үйл ажиллагаанд хяналт тавьдаг стандартын дагуу боловсронгуй болгох, тагнах үйл ажиллагаанд хүний эрхийн талаар баримтлах зарчим гэсэн дагнасан судалгааны ажил хийх нь тулгамдсан асуудал болно.

Тагнах үйл ажиллагааны шинэчлэлт, эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишиг, эрх зүйн шинжлэх ухааны онолын үүднээс авч үзэж, тагнах

асуудал” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ.2010. 86-95-р тал.

³¹Н.Энхбат. “Хилийн тагнуулын газраас гүйцэтгэх ажил явуулахад тулгамдаж буй эрх зүйн зарим асуудал”, Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ. 2010. 96-100-р тал.

³²Л.Нямзундуй. “Гүйцэтгэх ажлын тухай хуулийг боловсронгуй болгох зарим асуудлууд” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ. 2010. 102-110-р тал.

³³Б.Батхишиг. “Гүйцэтгэх ажлын зарчимд анхаарах асуудал, тэдгээрийг боловсронгуй болгох нь” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ. 2010. 111-118-р тал.

³⁴Ц.Алтанхүү.Төр нийгмийн зүтгэлтний амь биед халдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох гэмт хэргээс гүйцэтгэх ажлын эрх зүйн зарим асуудал” Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт онол, практикийн хурлын эмхтгэлд. УБ. 2010. 119-125-р талд.

үйл ажиллагааг онол арга зүйн үүднээс задлан шинжилж, ардчилал, даяарчлалын нөхцөлд тагнах үйл ажиллагааг түүхэнд гарч байсан алдааг давтахгүйгээр төгөлдөршүүлж зөвхөн хууль, эрх зүйн хүрээнд явуулах ёстой гэж үзэж байна;

Тагнах үйл ажиллагаа, түүний эрх зүйн үндсийг бүрэлдүүлэн тогтоосон асуудлыг авч үзэж, цаашид энэ үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг олон улсын энэ чиглэлийн эрдэмтэн судлаачдын бүтээлтэй харьцуулан, тагнах үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтыг эрх зүйн шинжлэх ухааны аргаар судалж боловсронгуй болгосноор тагнуулын байгууллага “үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах³⁵” баталгаа эрс дээшилнэ. Тагнуулын ерөнхий газрын харьяаллын гэмт хэргийг тагнах үйл ажиллагаа явуулж шалгах ажлын эрх зүйн эх сурвалж хууль тогтоомжийг улам боловсронгуй болгох, тагнах үйл ажиллагаа ба гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг шинжлэх ухааны аргачлалаар гүнзгийрүүлэн судлахыг зорилго болгох шаардлагатай.

Тагнах үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтыг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, тагнах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Монгол Улсад салбар эрх зүйн хэмжээнд хөгжүүлж, эрх зүйн шинжлэх ухаанд байр суурийг нь эзлүүлэх, энэ салбар эрх зүйг тагнуулын байгууллагын сургалтын нэгжээс гадна Монголын бүх эрх зүйн сургалтад судлах зүйл болгох нь тагнах үйл ажиллагааны нийгмийн ач холбогдлыг ойлгох, уламжлалт аргаар шийдвэрлэх боломжгүй ноцтой гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, мөн таслан зогсооход тагнах үйл ажиллагаа ба гүйцэтгэх ажлын арга, хүч, хэрэгслийг ашиглахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх ач холбогдолтой юм.

Тагнах ажиллагаа ба гүйцэтгэх ажлын ялгаатай ба төсөөтэй талууд Судалгаанаас үзэхэд үйл ажиллагаа нь хуулиар зохицуулагдсан мөртлөө тагнах ажиллагаа ба гүйцэтгэх ажил явуулдаг эдгээр 7 байгууллагыг хэн удирдаж, ажиллагааг нь хэн зохицуулах вэ гэсэн асуудал нэлээд маргаан зөрчилтэй, тагнах ажиллагаа ба гүйцэтгэх ажлын нэр томъёог нэг мөр ойлгох асуудал, тагнах ажиллагаа ба гүйцэтгэх ажлын онол практикийн асуудал, тагнах ажиллагааны ба гүйцэтгэх ажлын байгууллагын бүтцийн хувьд ч санал зөрөлдөөнтэй байна. Зарим нэг жишээ дурьдахад:

Судлаач З.Төрмандах өөрийн бүтээлдээ “АНУ-ын Холбооны Мөрдөх товчооны бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн хэм хэмжээ, үйл ажиллагааны

³⁵Монгол Улсын Тагнуулын байгууллагын тухай хуулийн 4-р зүйлд.

чиглэл зэрэг нь олон улс орны эерэг туршлагаар шалгарсан эрүүгийн цагдаагийн загвар мөн гэдгийг хүлээн зөвшөөрч өөрийн орны онцлог нөхцөл байдалд тохируулан хэрэглэх боломжийг судлах”³⁶ гэсэн санал дэвшүүлж, Эрүүгийн цагдаагийн газрын орлогч дарга Ш.Ганболд “Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалт” сэдэвт онол-практикийн хуралд тавьсан илтгэлдээ,...“Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх ажил явуулах байгууллага сөрөх тагнуул (Холбооны мөрдөх товчоо), хилийн чанадад гүйцэтгэх ажил явуулах байгууллага (гадаад тагнуул буюу Тагнуулын төв газар) байгуулж ажиллах болох эсэх саналыг судлах цаг нь ирсэн байна гэж үзэж байна”³⁷ гэсэн байна. Миний судалснаар бол тагнах ажиллагаа явуулдаг албад, гэмт хэргийг нууцаар мөрдөн шалгадаг гүйцэтгэх ажил явуулдаг албад хоёрын хооронд л санал зөрүүтэй, цаашид боловсронгуй болгох асуудал байгаа бололтой.

Тагнах ажиллагаа ба гүйцэтгэх ажил явуулдаг албадын ажиллагааны ялгаатай болон төсөөтэй талуудын тухай зөв ойлголт өгөхгүй бол санал зөрөлдөөнтэй асуудлыг шийдвэрлэхэд улам үл ойлголцох байдал үүсч болох юм.

Эдгээр албадын төсөөтэй талууд нь: бүгд тусгай арга, хүч, хэрэгсэл ашигладаг, нууц арга хэмжээний арга, хүч, хэрэгслээ чанд нууцлах зарчим баримталдаг, бүгд хүн эх сурвалж ашигладаг, тагнах ажиллагаанд ба гүйцэтгэх ажилд ашиглагддаг зарим арга нь төсөөтэй байна. Эдгээр төсөөтэй талаас нь шалтгаалж зарим судлаач, практикийн ажилтан өнгөц дүгнэлт хийж, бид адилхан чиг үүрэг гүйцэтгэдэг, адилхан зорилтыг хэрэгжүүлдэг, адилхан арга, хүч, хэрэгсэл ашигладаг учраас бусад албадын үүргийг бид ч гүйцэтгэж чадна, эдгээр албадыг нэгтгэж ч болно гэж андуурах нь бий. Судлаачийн хувьд миний бие үүнийг өрөөсгөл дүгнэлт гэж үздэг.

Эдгээр албад тийм механикаар нэгтгэх боломжгүй өөр “*өөрийн онцлог ялгаатай талууд*”-тай. Дээр миний дурдсанчлан тагнах ажиллагаа ба гүйцэтгэх ажил өөр өөр объектод чиглэж, эдгээр байгууллагууд өөр зорилго, зорилтыг хэрэгжүүлдэг. Бас өөр, өөр аргуудыг хэрэглэдэг. Гэмт

³⁶ З.Төрмандах. “Хүнийг санаатай алах гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаа” хууль зүйн доктор (Ph D)-ын зэрэг горилсон диссертацийн ажил. 2009. УБ. 132-р тал.

³⁷ Ш.Ганболд. “Гүйцэтгэх ажлын тухай хуулийг боловсронгуй болгох нь”, “Гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалт” сэдэвт онол-практикийн хурлын эмхтгэл. 2010. УБ. 32-р тал.

хэргийг нууцаар мөрдөн шалгах гүйцэтгэх ажлын байгууллагууд эрүүгийн гэмт хэрэгтнүүдтэй тэмцдэг бол тагнах ажиллагааны албад гадаадын тусгай албадын зориуд тагнах ажиллагаанд мэргэшүүлэн бэлтгэсэн тагнуулчдыг илрүүлэхээр ажилладаг онцлогтой.

Тагнуулчдыг тусгай сургуульд бэлтгэдэг, давтан бэлтгэж нарийн мэргэшүүлдэг. Тэдний эсрэг ажиллах сөрөх тагнуулчдыг ч удаан хугацаагаар бэлтгэдэг, мөн давтан мэргэшүүлдэг онцлогтой. Сөрөх тагнуулчид гадаад улсын тагнуулын албадаас зориуд мэргэшүүлэн бэлтгэсэн тагнуулчидтай тэмцдэгээрээ эрүүгийн гэмт хэрэгтэнтэй тэмцэхээс ихээхэн ялгаатай. Энэ ажиллагааг ихэвчлэн гадаадын тагнуулчдын санаархлыг гэмт үйлдэл болохоос нь өмнө, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахаас нь урьтаж тагнуулын (гэмт хэргийг нууцаар мөрдөн шалгадаг аргаас өөр) тусгай аргаар илрүүлж, урьдчилан сэргийлж, таслан зогсоодогоороо онцлогтой.

Сөрөх тагнуулын ажиллагааны ялгаатай талуудын талаар гадаадын судлаачдын бичсэн зарим жишээг татъя: Зэвсэгт хүчинд Ардчилсан хяналт тавих Женевийн судалгааны төвийн товхимолд... *“Сөрөх тагнуул нь мэдээллийн эх сурвалж, олсон мэдээлэл ба мэдээлэгчийг тал бүрээс нь шалгаж бодит үнэнийг тогтоох ажлыг хэрэгжүүлдэг тусгай албадын нэг төрөл юм. Сөрөх тагнуулын ажиллагаа бүхэлдээ эсрэг талын тусгай албад, эсхүл төрийн бус бүлэглэлүүдээс явуулдаг тодорхой аюул заналд цохилт өгч, тэдэнд хэсэгчилсэн байдлаар хариу үйлдэл хийдгээрээ бусад тусгай албадаас ялгагддаг. Сөрөх тагнуулын ажиллагааны үр дүн ихэвчлэн богино хугацаанд илэрч гардаггүй. Сөрөх тагнуулын албадын шалгах ажиллагааг цаг хугацааны хүрээгээр дураараа хязгаарлаж болдоггүй. Тагнуулчдыг барих нь эрүүгийн гэмт хэрэгтнийг барихаас илүү түвэгтэй зорилт юм. Гэмт хэрэгтнүүдэд дэмжлэг үзүүлэх санаархал ба эх сурвалж нь гадаадын тагнуулын байгууллагад дэмжлэг үзүүлэх сэдэлтээс ялгаатай. Ийм шалтгаанаар сөрөх тагнуулын албадын зохиох арга хэмжээнд эрүүгийн гэмт хэргийг илчлэх аргууд тохирдоггүй. Тийм ч учраас сөрөх тагнуулын албадыг эрүүгийн гэмт хэргийг илчлэх үүрэг бүхий албатай нэгтгэх нь буруу³⁸”* гэсэн байна.

Сөрөх тагнуулын ажил нь гадаадын тагнуулын алба, гадаадын байгууллага, тэдгээрийн төлөөний этгээдийн тагнах, хорлон бусниулах

³⁸ Деятельность спецслужб и демократический контроль-профессиональный взгляд. Бюллетень '3. Женев/Киев, Ноябрь 2005. Стр 19.

ажиллагааны эсрэг тактикийн өвөрмөц арга барил, хүч, хэрэгсэл ашиглан тэмцдэг, тагнах ажиллагаа явуулж илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажиллагаа нь эрүүгийн гэмт хэрэг, түүнийг үйлдэгчийг *нууцаар мөрдөн шалгах* арга, ажиллагаагаар тэмцэх бусад байгууллагын ажиллагаа, арга, хүч, хэрэгслээс ялгагдах онцлогтой. Тухайлбал, сөрөх тагнуулын ажил нь “гүйцэтгэх ажил” гэж нэрлэгддэг гэмт хэргийг нууцаар мөрдөн шалгах ажлаас доор дурдсан үндсэн ялгаатай. Гүйцэтгэх ажил нь хүн ба нийгэм, төрийг гэмт халдлагаас хамгаалах зорилготой бол харин тагнах ажиллагаа нь гадаадын тусгай албад, байгууллагууд (тэдгээрийн төлөөний этгээдийн) үндэсний аюулгүй байдлын язгуур ашиг сонирхолд хор, хохирол учруулах гэж буй талаар мэдээ, мэдээлэл олж сөрөх тагнуулын тусгай арга, хүч, хэрэгслийг ашиглан тагнах, хорлон бусниулах ажиллагаанаас сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба сөрөх тагнуулын арга хэмжээ зохиож хувь хүн, нийгэм, үндэсний аюулгүй байдлыг хангах гэсэн зааг ялгааг нарийвчлан тодорхойлох нь онол практикийн ач холбогдолтой.

Үйл ажиллагаа нь “гэмт хэргийн хэлбэрт шилжээгүй объект дээр гүйцэтгэх ажлын арга”-ыг ашиглаж болохгүй. Тэнд зөвхөн сөрөх тагнуулын илрүүлэх (*загварчлах, туршилт хийх, үг алдуулах* гэх мэт), урьдчилан сэргийлэх (*тагнах, хорлон бусниулах ажиллагаа явуулахаас татгалзахад нөлөөлөх, чиглэлгүй болгох, чиглэж буй объектыг халхавчлах, сонирхож буй объектод холбоо тогтоох, холбоогоо бэхжүүлэх арга замыг хязгаарлах* гэх мэт), таслан зогсоох (*тагнах хорлон бусниулах байгууллага, бүлгийг задлан бутаргах, эсрэг этгээдийг илчлэх, тэдгээрийн зорилго, арга, хэлбэрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр илчлэх, тагнах хорлон бусниулах ажиллагааг гурав дахь этгээдээр дамжуулан илчлэх, эсрэг этгээд өөрийгөө илчлэх нөхцөл бүрдүүлэх, холбогдолд оруулах* гэх мэт) аргыг ашигладаг нь гэмт хэрэг ба гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох гүйцэтгэх ажлын аргуудаас ялгагддаг. Дээр дурдсанаас өөр олон арга бий боловч тагнуул, сөрөх тагнуулын аргууд нь ихэвчлэн нууцын зэрэгтэй эрх зүйн актаар зохицуулагддаг учраас энд зөвхөн нээлттэй ном хэвлэлд бичснийг нь л дурдлаа.